

## “ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГУУДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ЭКОСИСТЕМИЙГ ХАДГАЛАН ХАМГААЛАХАД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ НЬ II” (SPACES II)

### НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол орны байгалийн олон төрлийн бүс, бүслүүр нь зэрлэг амьтан, ургамлын олон төрөл зүйлийн амьдрах орчныг бүрдүүлж байдаг. Эдгээр биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээ нь Монгол улсын нийгэм, эдийн засаг, соёлын болон хөгжлийн үндэс нь юм. Биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор Засгийн газраас нийт нутаг дэвсгэрийн 21 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад аваад байна.

Хэрэгжиж буй арга хэмжээ бий боловч, Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн өнөөгийн тогтолцоо нь байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлж чадахгүй байна. Байгалийн нөөц баялгийн буруу ашиглалт, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нь тусгай хамгаалалттай газар нутагт (ТХГН) болон орчны бүсийн биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээнд ихээхэн аюул учруулж байна. Цаашлаад холбогдох байгууллагуудад санхүүжилт, мэргэжлийн боловсон хүчин, техникийн ур чадвар, хүний нөөц дутмаг зэрэг тулгамдсан асуудлууд байна.



Орон нутгийн хүн амын нэлээд хэсэг нь тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд амьдардаг бөгөөд тэдгээрийн амьжиргаа нь байгалийн нөөц баялгаас шууд хамааралтай. Эдгээр газар нутаг эрсдэлд орсноор нутгийн иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж буй нь орчны бүс дэх байгалийн баялгийг хэт ашигласнаас мөн үүдэлтэй. Байгалийн баялгийг тогтвортой ашиглах, мөн хүн амын дунд байгалийн ландшафтыг хамгаалахад хэрхэн хувь нэмрээ оруулах талаар мэдлэг дутмаг байна.

Бид тогтвортой хөгжлийн дараах зорилгуудад хувь нэмэр оруулж байна...



### Захиалагч

ХБНГУ-ын Эдийн засгийн  
хамтын ажиллагаа, хөгжлийн  
яам (BMZ)

### Төсөл хэрэгжих бүс нутаг

Хан Хэнтийн УТХГ,  
Тарвагатайн нуруу БЦГ, Хомын  
тал БЦГ, Ховд аймаг

### Хамтран хэрэгжүүлэгч

Монгол Улсын Байгаль орчин,  
аялал жуулчлалын яам

### Хэрэгжих хугацаа


2024 - 2028

### Нийт санхүүжилт

6.000.000 евро

### ЗОРИЛГО

### Зорилтот газар нутаг



Сонгогдсон тусгай хамгаалалттай газар нутагт ландшафтын түвшинд тогтвортой, жендерийн мэдрэмжтэй менежментийн санаачилгыг нутгийн иргэдийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.



### Бодлогын зөвлөгөө (Үндэсний түвшинд)

Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчныг бэхжүүлнэ. SPACES I нь тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчлэлийг дэмжиж байсан бол одоо тус шинэчлэл нь үндэсний болон тусгай хамгаалалттай газар нутгийн нарийвчилсан зохицуулалтаар нотлогдсон байна. Энэ нь хамтын менежмент, бие даан санхүүжүүлэх механизмыг бэхжүүлэх замаар тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг илүү үр ашигтай болгоно.



Хан Хэнтийн ТХГ-ын байгаль хамгаалагчид



GIZ-ийн дэмжлэгтэйгээр Хан Хэнтийн ТХГ-т аяллын маршрут байгуулав



### Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бэхжүүлэх (Сонгогдсон ТХГН)

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад үндэслэн ой, хог хаягдал, аялал жуулчлалын менежментийн чиглэлээр тусгайлсан арга аргачлал болон тусгай хамгаалалттай газрын хамтарсан менежментийг бэхжүүлнэ. Үүний тулд төсөл нь тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаанд техникийн зөвлөгөө өгөхийн зэрэгцээ иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудтай холбогдох нэмүү өртгийн сүлжээнд хамтран ажиллана.



### Байгаль орчны мэдээлэл сургалт сурталчилгаа (Сонгогдсон ТХГН)

Байгаль орчны мэдээлэл сургалт сурталчилгааг (БОМСС) сайжруулах арга аргачлалыг тусгай хамгаалалттай газарт туршиж, үндэсний түвшинд ашиглах боломжийг бүрдүүлнэ. Төсөл нь тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны ажилтнуудад БОМСС-ын асуудлаар зөвлөгөө өгч, байгаль хамгаалагчдад болон хүүхэд залуучуудад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулна. Энэ бүх ажил нь ТХГН-ийн шинэ хуулийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээс гадна олон нийтийн дунд ТХГН-ийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлж байгаль орчныг хамгаалахад хувь нэмэр оруулна.



Ховд аймгийн ЕБС-ийн эко клубүүд Байгаль орчны боловсролын хөтөлбөрт хамрагдав

Хэвлэлтийг: Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) GmbH  
Оффис ХБНГУ-ын Бонн, Эшборн хотуудад байршилтай

Холбоо барих: Др. Михаэл Трокенбротт  
"Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь II" (SPACES II) төсөл

Найман зовхис барилгын III давхар, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар  
14251, Монгол улс  
Т: +976 11 312282  
E: michael.trockenbrodt@giz.de  
I: www.giz.de

Хамтран хэрэгжүүлэгч: Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)

Дизайн/зураг: GIZ Монгол

Захиалагч: ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)

Он, сар: 2024 оны 1 дүгээр сар

Хэвлэлийн агуулгыг Монгол дахь GIZ хариуцна.